

# УЛСЫН ШАЛГАЛТ - 2023

## МОНГОЛ ХЭЛ

### ХИИ АНГИ

Аймаг/дүүрэг: .....

Сум: .....

Сургууль: .....

Анги: ..... Бүлэг: .....

Овог: .....

Нэр: .....

#### САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 80 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

## Цаст уулын чулуу

Би анх гаднаас захидал авсан мөчөө хүнд хэрэгтэй болж эхэлсэн үе гэж санадаг. Тэгж санаснаасаа ч болсон уу, өөр хадгалах хогшилгүйдээ ч тэгсэн үү, бусдаас авсан бүхий л захидлыг нандигнан цуглуулж эхэлсэн бөгөөд аргалын утаанд олон жил утагдсан зандны өнгөтэй болсон гоёмсог шоголд тэднийгээ хадгалах болсон юм.

Бидний багад эмээ энэ шоголд “Алтангэрэл” –ээ хийж дэрэн тушаагаа тавиад тэнгэр дуугарах бүрий аянгын дуутай зэрэгцэн түүгээрээ адисална. Уулга алдахдаа ч чанга буулгачихдаг юм уу, заримдаа толгой дүүртэл адислахад нь нөгөө аянга нь буучхав уу гэж бодогдох удаа ч байсан. Эмээ минь адисалж дуусаад биднийгээ тэнгэрийн дуунаас аварчихлаа гэж боддог сон уу, Жавхлант хайрхныхаа оройд буух аянгын хүчийг тэр л уулынхаа үр сад болох бидний толгойд сарниан тарааж байна ч гэж санадаг байсан уу, их л юм бүтээчихсэн бололтой суудаг сан.

Эмээг өөд болоход “Алтангэрэл” нь яасан ч юм бүү мэд. Энэ л шогол нь үлдчихээд, эхлээд дүү нар шагай хурааж, дараа нь би захиа хийх болсон юм.

Одоо энэ хайрцагт гурван зуугаад захидал буй. Энэ дотор инээд баяр, учраа болзоо, үхэл хагацал, уур унтуу, ер хүний орчлонд байдаг бүхэн биесээ дэрлэн нойрсох боловч тагийг нь онгойлгох төдийд олон жил барьсан эсгий туурганы өнгөт цааснууд нь амь орон, шөнө дүл түргэн жагсаал авсан цэргийн хуаран шиг дүрхийн шавгиналдана. Тэгээд олон янзын хэлээр бие биеэсээ өрсөн: инээж, уйлж, ярьж, зөвлөж гуйж, зүхэж эхэлнэ. Хэчнээн янзын араншин, хэчнээн бодол, мөрөөдөл, цөхрөл энэ жаахан хайрцагт багтана вэ? Ганцхан захидлын түүхийг өгүүлсүгэй.

Хортой харандааны үзүүр норгон байж бичсэн энэ нэгэн захидал Данзан гуайнх. Хэдэн ч өдөр юм бэ, амран амран байж бичсэн энэ хэдэн мөрөнд дүрмийн хувьд зөв бичсэн нэг ч үг байхгүй мөртөө бүхэлдээ хорвоотой тэнцэх үнэ байлаа.

Данзан гэдэг энэ тангад хүн хэзээ ямар хувь зохиолоор цаст уулнаасаа бууж ирээд говийн тэрхүү элс шуурсан хонхорт хоргодох болсныг хэн ч мэддэггүй. Мөнхийн хүрэн цохио, Гурван Хөвсгөлийн уултай адил заавал байх ёстой юмны нэг мэт бодоцгоодог байжээ. Дөчөөд оноос хойш хорин жилийн дотор сумын сургуулиар дамжиж гарсан олны дунд Данзан гуайн хийсэн хоол, чанасан боовноос амсаагүй нь нэгээхэн бээр үгүй. Бас “Буга согоо” хэмээх түвд дуу дуулахыг нь сонсоогүй хүн тэдний дунд байхгүй биз ээ. Сургуулийн улаан буланд үдэшлэг хийх болгонд Данзан гуай хэдийнээ ирээд суучихсан байх бөгөөд үдэшлэгийн ажиллагаа талдаа орохын анзаанд зарлан удирдагч голлуулж тавьсан улаан бүтээлэгтэй ширээ түшин зогсож, шалнаас боссон тоос, хүүхдүүдийн шуугиан хоёр намдахыг жаал хүлээж байснаа:

Одоо тогооч Данзан гуайн авьяасыг үзье! гэж цангинуулан хэлэхэд Данзан гуай инээмсэглэн босож ирээд:

За одоо би “Буга согоо” гэж түвд ардын дуу дуулна гэж үргэлж дэргэд нь байдаг биднээс өөр хэн ч ойлгохгүй хэлээр хэлээд дуулж гарна. Бид Данзан гуайн ярьсныг ойлгох болсноо түвд хэлтэй болсны дайтай бодож явсан удаа ч буй. Хад чулуу шиг хүдэр том биетэй тэр өвгөн зангилаатай гарын дайны том хамраа өргөн урамдах дүр үзүүлж, хураагаараа цагариг гарган нүдэндээ барьж худлаа юм шиг бархиран дуулахад нь хүүхдүүд алиалж байна гэж бодоход дэмий л инээлдэж байдаг сан. Данзан гуай энэ л дуугаа дуулах гэж үдэшлэгт ирдэг байжээ. Хааяа гаднаас зочидтой үед Данзан гуайн авьяасыг үзэх уламжлалт номероо мартаж орхивол өөрөө сануулж байгаад дуулна. Дуулж байхад нь онигор нүднээс нэгэн харам цэхэр нулимс сэмээрхэн мөлхөн гарч ирээд ичингүйрэх мэт түр саатан зогссоноо гэнэт ухасхийгээд зовхины доод гүн нугалаа руу орж алга болно. Манай нутгийнхнаас “Данзан гуайг мэдэх үү!” гэж асуувал бүгд “сайн

мэднэ” гэлцэх биз. Гэхдээ тэрхүү ичимхий цэхэр нулимсыг ажиглаж мэдсэн хүн тийм ч олон байхгүй биз ээ.

Дотуур байрныхан гэдэг цатгалан ч дандаа санаа нь дундуур явдаг хойно доо, гал тогооны ерөөгөөр гүйж, тогоочид шадарлах хүүхэд мундахгүй. Данзан гуай өөрөө ээлжээр дуудаж хамжаа авна. Би нэг өдөр ээлждээ хуушуур хийлцэж байгаад:

Та яагаад дуу дуулахдаа уйлдаг юм бэ? гэж асуухад Данзан гуай гэмшингүй инээмсэглэж, нэг санаа алдсанаа эргэж устай шүүрээр хуушуур утган пис пасхийтэл тос шажигнуулаад тодорхой юм хэлсэнгүй. Би ч дахиж асуухаа мартаж орхисон билээ. Гэтэл тэр асуултын хариу бүр хожим олоон жилийн дараа ирсэн нь тэрхүү харандаагаар бичсэн захидал байлаа. Тэр захидалд: “- Чи намайг нутгийн дуу дуулахдаа яагаад уйлдаг юм бэ?” гэж асууж байсан. Одоо ойлгож байна уу?” гэжээ.

Тийм ээ, би ойлгосон. Карпатын ууланд бэлцгэр ногоон навчсын сүүдэрт амарч суухдаа ч Бессрабийн толгодод усан үзмийн цэцэрлэгээр зугаалж явахдаа ч, их уст Севанд гараа угааж, нарны цус шиг Араратын шимийг хүртэж байхдаа ч араанд минь шажигнаж байдаг шаргал элс, багын тоглоом өрөөстэй улаан дэлүүд, тэмээний мөрөөр давс шүдэлдэг Сайн төгрөгийн тойрмыг огтоос мартаж үзээгүй ээ.

Сургууль төгсөж ирээд би ижил олон толгодын маань нэг нь байхгүй юм шиг Данзан гуайгаа ихэд үгүйлж билээ.

Явуулын уул байгаад нүүчихсэн юм шиг санагдаад байхлаар шарил дээр очлоо. Эгэл нэгэн заяа, эгэл нэгэн чулуу байлаа. Чулуу хүртэл нутгаа санадаг ажээ.

*Ж.Лхагва*

**Даалгавар 1.** Эхийг бүтцээр нь зөв зааглан ялгаж, хэсэг бүрд өгүүлэгдэж буй агуулгаар нэр өгөөрэй. (2 оноо)

Эхлэл хэсэг: .....

Гол хэсэг: .....

Төгсгөл хэсэг: .....

**Даалгавар 2.** Эхээс нийгмийн болон соёлын хам сэдвийн жишээ нэг нэгийг олж бичээрэй. (2 оноо)

Нийгмийн хам сэдэв: .....

Соёлын хам сэдэв: .....







### **Засагч багш нарт:**

Шалгалтын материалыг засаж оноожуулахаас өмнө засалт хийх багш нар бүгд материалыг уншиж, оноо өгөх нэгдсэн нэг ойлголттой болно.

Боломжтой бол засагч багш нар ажлаа хуваарилахдаа материалын тоог тэнцүүлж, таван багшид дөч дөчин материал гэх биш, бүх шалгуулагчийн 1-3-р даалгаврыг нэг багш, 4-7- даалгаврыг нэг багш, 8-р даалгаврыг гурван багш гэх мэтээр хуваарилах. Энэ нь шалгалтын дүн үнэн зөв, шударга, бодитой байхад эерэг нөлөөтэй.

Шалгалтыг зөвхөн 0, 1, 2, 3 гэх мэт бүхэл оноогоор дүгнэнэ. 0.5, 1,5, 2,5 гэх мэт бутархай оноог ямар ч тохиолдолд өгөхгүй.

### **Оноо өгөх зарчим:**

#### **Даалгавар 1. Нийт 2 оноо**

Эхийн бүтцийг зөв зааглан агуулгыг хангахуйц нэрлэсэн бол 2оноо

Эхийн бүтцийн аль нэг хэсгийг буруу заагласан эсвэл аль нэг хэсэгт оноосон нэр тохиромжгүй бол 1 оноо

Эхийн бүтцийг бүхэлд нь буруу заагласан, хэсгүүдэд оноосон нэршил тохиромжгүй эсвэл даалгаврыг гүйцэтгээгүй бол 0 оноо

#### **Даалгавар 2. Нийт 2 оноо**

Нийгмийн болон соёлын хам сэдвээс нэг нэг жишээ татан бичсэн бол 2 оноо

Нийгмийн болон соёлын хам сэдвээс аль нэгийг нь бичсэн эсвэл хоёул нэг хам сэдвийг илтгэж байвал 1 оноо

Сонгосон хэсэг нь хам сэдэв илтгэхгүй, хамааралгүй зүйл байх эсвэл даалгаврыг гүйцэтгээгүй бол 0 оноо

#### **Даалгавар 3. Нийт 3 оноо**

Эхэд гол болгон дэвшүүлсэн асуудлыг олсон бол 1 оноо

Эхэд дэвшүүлсэн асуудлыг зөв олоогүй бол 0 оноо

Асуудлыг тодруулахад чухал үүрэгтэй буюу санаагаа баталсан баримт 2 ба түүнээс дээш олж бичсэн бол 2 оноо /баримтууд гэж олон тоо заасан байгааг сурагч анзааран бичсэн байх ёстой/  
Асуудлыг тодруулахад чухал үүрэгтэй буюу санаагаа баталсан баримт нэгийг олж бичсэн бол 1 оноо

Олж бичсэн баримт нь санааг дэмжээгүй, утга, агуулгын зөрөөтэй бол 0 оноо

#### **Даалгавар 4. Нийт 3 оноо**

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон бол 2 оноо

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон боловч, өөр өгүүлбэр хамт бичсэн эсвэл цогцолбороор нь авсан бол 1 оноо

Эхийн гол санааг илэрхийлэх өгүүлбэрийг олж чадаагүй бол 0 оноо

Өөрийн үгээр зөв тайлбарласан бол 1 оноо

Гол санааг буруу тайлбарласан эсвэл сонгосон өгүүлбэртэй хамааралгүй зүйлс бичсэн бол 0 оноо

#### **Даалгавар 5. Нийт 3 оноо**

Сонгосон баримт нь (1) зохиогчийн үзэл бодлын эсрэг байр сууринаас хандсан, (2) шинжлэх ухааны үндэслэлтэй, тодорхой эх сурвалжтай, (3) үнэн зөв, ёс зүйн болон оюуны өмчийн зөрчилгүй бол 3 оноо. (1), (2), (3)-ыг тус бүр 1 оноогоор дүгнэж, аль нэгийг хангаагүй тохиолдолд оноог хасна. Мөн нэг баримт дутуу бичсэн бол 1 оноо хасна.

#### **Даалгавар 6. Нийт 2 оноо**

Хэлцийг дэлгэрүүлсэн өгүүлбэр зөв бүтэцтэй, найруулгын ямар ч алдаагүй бол 1 оноо

Өгүүлбэрт бүтэц найруулгын алдаа гарсан бол 0 оноо

Хэлц өгүүлбэрийг “гэ-, хэмээ-“ холбох үг ашиглан дэлгэрүүлсэн бол 1 оноо

XII ангийн агуулгаар үзэж судалсан “гэ-, хэмээ-“ холбох үгсийг ашиглаагүй бол 0 оноо

#### **Даалгавар 7. Нийт 5 оноо**

0-1 алдаатай хөрвүүлсэн бол 5 оноо

2-3 алдаатай хөрвүүлсэн бол 4 оноо

4-5 алдаатай хөрвүүлсэн бол 3 оноо

6-7 алдаатай хөрвүүлсэн бол 2 оноо

8-9 алдаатай хөрвүүлсэн бол 1 оноо

10 ба түүнээс дээш үг алдаатай хөрвүүлсэн бол 0 оноо

**Даалгавар 8. Нийт 20 оноо**

<b>агуулга</b>	<b>ОНОО өгөх заавар</b>	<b>ОНОО</b>
Сэдэв ба зорилго	Зорилгоо хангаж бодит шийдэл санал болгож, учир шалтгааны уялдаа холбоотой сайтай бичсэн бол	<b>5</b>
	Учир шалтгааны уялдаа холбоо бага зэрэг алдагдсан бол	4
	Учир шалтгааны уялдаа холбоо муутай ч нэгэн сэдвээр бичсэн бол	3
	Сөрөг хандлагатай эсвэл хэд хэдэн асуудлыг хөндсөн бол	2
	Ямар нэгэн зохиол бүтээлээс санаа авсан, санааг давтсан бол	1
	Сэдэв, зорилгоос хазайсан, хуулсан бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Эшлэл баримт	Эшлэл, баримтыг оновчтой ашигласан бол	<b>2</b>
	Тохиромжгүй ч эшлэл, баримттай бол	1
	Эшлэл, баримтгүй бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бичлэгийн хэлбэр төрөл	Тодорхой хэрэгжүүлж болохуйц бодитой шийдлийг санал болгож байгаа бол	<b>2</b>
	Тодорхой шийдэл санал болгосон ч бодитоор хэрэгжих боломжгүй бол	1
	Ямар нэгэн бодит шийдэл санал болгоогүй, шүүмжийн шинжтэй бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бүтэц	Эхийн бүтэц ойлгомжтой, догол мөр, зайгаар заагласан бол	<b>3</b>
	Эхийн бүтэц ойлгомжтой хэдий ч догол мөр зайгаар зааглаагүй бол	2
	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн аль нэг нь дутуу бол	1
	Эхийн бүтэц тодорхой зааггүй, санаа бүрэн биш бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэл зүй, найруулга	Хэл зүй найруулгын алдаагүй	<b>3</b>
	Хэл зүй найруулгын багахан алдаатай ч ерөнхий цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгад нөлөөлөөгүй бол	2
	Хэл зүй найруулгын алдаа нь тухайн цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгыг сулруулсан бол	1
	Хэл зүй найруулгын алдаа их бол /4+ алдаа/	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Үгийн тоо	250-280 хооронд бол	<b>1</b>
	Үгийн тоо их, бага бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Зөв бичгийн дүрэм	0-1 алдсан бол	<b>3</b>
	2-5 алдсан бол	2
	6-9 алдсан бол	1
	10+ бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бичгийн соёл	Уншиж ойлгоход саадгүй бол /дармал байж болно/	<b>1</b>
	Уншиж ойлгоход хэцүү, үсэг, тэмдэг хооронд ялгаагүй бичсэн бол.	0
	<i>хийгээгүй бол</i>	X